



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№117 /331/

2022.06.30

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ УЛСАД СУУГАА БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕ НАРТ НАЙРАМДЛЫН ОДОНГ ГАРДУУЛАВ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай үүрэгт ажил нь дуусан эх орондоо буцаж буй Монгол Улсад суугаа АНУ, БНСУ, Япон улсуудын Батлан хамгаалахын атташе нарын хүлээн авч хүндэтгэл үзүүлэн найрамдлын одонг гардуулан өглөө. Тэрээр дээрх орны Батлан хамгаалахын атташе нарт хандан "Та бүхэн өөрсдийн орны Засгийн газраас

даалгасан эрхэм хүндтэй албыг нэр төртэйгөөр хашиж хоёр орны Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаад талархал илэрхийлье. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас олон бэрхшээл тулгарч байсан хэдий ч хоёр улсын Батлан

хамгаалах харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутгийн хэмжээнд цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, Батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх, даян дэлхийн энх тайвны төлөөх үйлсэд оролцох оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг тасралтгүй явуулж, батлан хамгаалах салбарын

хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулан ажилссаныг дурдахад таатай байна. Цаашид ч та бүхэн хоёр улсын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулан ажиллана гэдэгт итгэлтэй байна" гээд цаашдын ажил хөдөлмөрт нь амжилт сайн сайхан бүхнийг хүслээ.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИУДАД АЖИЛЛАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах салбар манлайлан оролцож байгаа билээ.

Тэгвэл тус хөдөлгөөний хүрээнд БХЯ, түүний харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудад ногоон хотхон байгуулах, агро-ойжуулалтыг хөгжүүлэх ажлууд ид өрнөж байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний, 014, 353, 015 дугаар ангиудад ногоожуулах, цэцэгжүүлэх чиглэлээр багагүй ажлууд хийгдэж байгаа бөгөөд тус ажлын үйл явцтай Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг өчигдөр танилцлаа. Дээрх гурван ангийн хувьд ургуулж хийж бүтээж буй ногоон байгууламжаа илүү ихээр арчилж, хайрлаж улам төгөлдөржүүлэхийг дэд сайд Б.Баярмагнай үүрэг болгосон юм.

Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудын 50 байрлалд үе шаттайгаар 2022 оноос 2030 он хүртэл хэрэгжүүлэх юм. Мөн "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон хангайн бүс, говийн бүсэд байрлах Зэвсэгт хүчний 9 ангийн байршилд 7 мод үржүүлгийн газар, 2 Мод үржүүлэг-агроэкологийн сургалтын төвийг байгуулахаар ажиллаж байна. Тодруулбал, Дорноговь

аймгийн Өргөн сум Зүүнбаянд Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн 10 га талбай, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн 8 га талбайд.

Харин мод үржүүлгийн газрыг

1.Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Сонгинод Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн 2 га талбай;

2.Төв аймгийн Батсүмбэр суманд Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн 5 га талбай;

3.Төв аймгийн Алтанбулаг суманд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн 2 га талбай;

4.Завхан аймгийн Улиастай хотод Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 2 га талбайд;

5.Эрдэнэт хотод Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн 3 га талбайд;

6.Говьсүмбэр аймгийн нутагт Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн 4 га талбайд

7.Дорнод аймгийн Чойбалсан суманд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн эзэмшлийн 3 га талбайд тус тус 39 га талбайд байгуулахаар ажиллаж байгаа юм.

Мөн нэгтгэл, анги, байгууллагын өнгө үзэмжийг дээшлүүлэх, эрүүл ногоон орчныг Үргэлжлэл нь арын нүүрт

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 16


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.146.00	3.152.0
EUR 🇪🇺	3.290.0	3.325.0
CNY 🇨🇳	471.50	473.00
RUB 🇷🇺	54.50	56.00
JPY 🇯🇵	23.10	23.40
KRW 🇰🇷	2.41	2.46

ЗУРХАЙ



2022.06.30 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 1

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХӨХ БАР ӨДӨР

Үс засуулбал:

Нас ахар болно

Наран ургах, шингэх:
04.56-20.55

Барилдлага:

Хотол чуулган

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал: Төмөр

Энэ өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнэс эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрийн үйлд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 551,874,137

Эдгэрсэн

Нийт: 527,382,985

Нас барсан

Нийт: 6,356,428

Цахим шууданд

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИУДАД АЖИЛЛАВ



Түрүүч нь эхний нүүрт байгуулах зорилгоор Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл анги, салбаруудын нийт 50 байрлалд 2030 он хүртэл хугацаанд төслийг хэрэгжүүлнэ.

Энэхүү төслийн хүрээнд Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын байрлалд 800.000 мод бут, сөөг тарьж ургуулах юм. 2022 онд Зэвсэгт хүчний 014, 256, 336, 350, 353



дугаар ангиудыг жишиг эко ногоон хотхон болгохоор зорилт тавин мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах юм.

2021 онд Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг жишиг ногоон хотхон

болгох зорилтын хүрээнд 14 нэр төрлийн 8485 ширхэг мод, бут, олон наст ургамал бүхий ногоон байгууламж, гэрэлтүүлэг бүхий явган хүний зам, талбай, гүйлтийн зам, спорт тоглоомын талбайг байгуулсан юм.

БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ "ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ" СУРГАЛТ ЯВУУЛЛАА



Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022

оны А/202-р захирамжийн дагуу багийн Засаг дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг Хилийн цэргийн 0245 дүгээр ангийг түшиглэн энэ 22-24-ний хооронд зохион байгууллаа.

"ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН" ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМД ТЕХНИКИЙН КОМИСС АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Зэвсэгт хүчин нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Цогтцэций өртөөнөөс гол шугамын 129 дүгээр километр буюу Ар хонгилдог зөрлөг хүртэлх хиймэлбайгууламж,дээд,доод бүтцийн ажлыг гүйцэтгэсэн бөгөөд дээрх бүтээн байгуулалтуудыг ашиглалтад оруулах урьдчилсан дүгнэлт гаргах техникийн комисст шалгууллаа.

ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Булганхүүгээр ахлуулсан Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын хөгжлийн төв, Зураг төслийн байгууллага, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газар, "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн төлөөлөл бүхий 60 гаруй хүний бүрэлдэхүүнтэй эл комисс энэ сарын 23-25-ны өдрүүдэд ажилласан юм. Энэ хугацаанд тус комисс нь зураг төсөл, далан, газар шорооны ажил, гүүр хоолой

хиймэл байгууламжийн холбогдох баримт бичгийг хянаж төмөр замын барилгын стандарт, холбогдох норм дүрэм, техникийн шаардлагад нийцсэн эсэхийг шалган, дүгнэлт гаргав.

Мөн Цогтцэций өртөөнөөс гол шугамын 129 дүгээр километр хүртэлх төмөр замын техникийн байдалд үзлэг хийсэн ба техникийн комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр Улсын комисс ажиллуулахыг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.

Ийнхүү Монгол Улсын Зэвсэгт хүчин нь улс, эх орны стратегийн томоохон бүтээн байгуулалт болох Таван толгой-Зүүнбаян чиглэлийн 416,1 километр "Шинэ төмөр зам" төсөлд оролцож, үндэсний бүтээн байгуулагч 46 аж ахуйн нэгжийн хамт 24,296,141 м.куб газар шорооны ажил, ус өнгөрүүлэх 595 ширхэг төмөр бетон хоолой, 66,139 м.куб бетон зуурмаг, нэг гүүр, нэг өртөө, зургаан зөрлөгийн барилга, 221 километр дээд бүтцийн ажлыг тус тус гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн боллоо.

Дэслэгч Б.БАТМӨНХ



ЗАСВАРЫН БҮЛЭГ ҮҮРГЭЭ АМЖИЛТТАЙ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар Агаарын цэргийн командлалын Материал техникийн хэлтсийн ахлах офицер хурандаа С.Дашдондоогоор ахлуулсан Зэвсэгт хүчний 011, 065 дугаар ангийн офицер, ахлагч нараас бүрдсэн засварын бүлэг Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа тусгай салбаруудын радиолокацын станцын болон тээврийн бүлгийн авто техникүүдэд сэргээн сайжруулах засвар үйлчилгээг энэ сарын 9-ний

өдрөөс эхлэн хийж гүйцэтгэж байна. Тус засварын бүлэг нийт 9 тусгай салбараар 30 хоногийн хугацаанд радиолокацын станц, авто техникүүдийг сэргээн сайжруулах, өнгө үзэмжийг сэргээх, шаардлагатай засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх юм. Өнгөрсөн жил тус бүлэг нь Зэвсэгт хүчний 123, 065, 325 дугаар ангиудад болон зарим тусгай салбаруудад автын засварын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн юм.

Хурандаа С.ДАШДОНДОГ

АЙМГИЙН "ДӨЛ"-ИЙН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Аймгийн аварга шалгаруулах Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын "ДӨЛ" 2022 тэмцээний хоёрдугаар шат амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун,

сэтгэл зүйн хүмүүжил олгох, батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах зорилготой Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд зохиогддог дээрх тэмцээнд 4 сумын 11 сургуулийн 120 гаруй сурагч, багш, дасгалжуулагчид оролцлоо. Баг тамирчид 9

төрлийн тэмцээнээр хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт 88.3 оноогоор Сайншанд сумын IV сургуулийн Б.Хос-Эрдэнэ захирагчтай тасаг, дэд байрт 74.3 оноогоор Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Г.Хатантулга захирагчтай тасаг, гуравдугаар байрт 66.8 оноогоор Замын-

Үүд сумын II сургуулийн Б.Баттулга захирагчтай тасаг тус тус шалгарлаа. Тэргүүн байранд орсон баг тамирчид энэ оны 8 дугаар сард Улаанбаатар хотод Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах Цэрэг-спортын "ДӨЛ" 2022 Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоно.

